



# СОЁМБОМ ЭДЭЭ

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

МОНГОЛ УЛСЫНХАА ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ!

№230 /439/

2022.12.21

Цаг үе, үйл явдал

## JCI MONGOLIA БАЙГУУЛЛАГААС "ШИЛДЭГ 10 ЗАЛУУ"-ГИЙН НЭГЭЭР ДЭД ХУРАНДАА Э.БИЛЭГСАЙХАНГ ОНЦОЛЛОО



Нийгэмд эерэг нөлөөлөл түгээж, залуусын манлайлал, хөгжлийг дэмжигч JCI Монгол байгууллагаас 2022 оны энх тайван, хүмүүнлэг, эрүүл мэнд зэрэг хэд хэдэн салбараас 10 манлайлагчийг тодруулжээ.

Шилдгийн шилдэг 10 залуусын нэгээр Зэвсэгт хүчний 016 дугаар нэгтгэлийн захирагчийн орлогч, штабын дарга, дэд хурандаа Э.Билэгсайхан шалгарч, JCI Монгол байгууллагын 2022 оны Үндэсний ерөнхийлөгч Ж.Дамдинцэрэнгээс шагналаа гардан авсан байна.

Тус байгууллагын мэдээлэлд "Даян дэлхийн энх тайван, тухайн улс орны тусгаар тогтнол, бүс нутгийн аюулгүй байдал, хүний эрх, эрх чөлөөг эрхэмлэн дээдэлж, олон улсын энхийг сахиулах ажиллагаанд гурван удаа үүргээ нэр төртэй гүйцэтгэж Монгол Улс, Зэвсэгт хүчний нэр хүндийг дэлхийн тавцанд өндөрт өргөсөн Монголын шилдэг залуу офицеруудын нэг нь дэд хурандаа Э.Билэгсайхан юм.

Тэрээр Бүгд Найрамдах Сьерра Леон улс, Исламын Бүгд Найрамдах Афганистан улсад энхийг сахиулах үүргээ нэр төртэй гүйцэтгэсэн ба орон нутгийн иргэдийн аюулгүй байдал, бааз дотор үүрэг гүйцэтгэж буй 21 орны 5000 гаруй цэргийн алба хаагчдын амь нас, эрүүл мэндийг хамгаалахад үнэтэй хувь нэмэр оруулсан энхийг сахиулагч.

Хамгийн сүүлд гэхэд 2019-2020 онд ИБНАУ-д явагдаж байсан "Шийдвэртэй дэмжлэг" ажиллагаанд ХБНГУ-ын Зэвсэгт хүчинтэй хамтран үүрэг гүйцэтгэсэн Монгол Улсын XI цэргийн багийн захирагчаар ажиллаж, эх орон, Зэвсэгт хүчний өгсөн даалгаврыг нэр төртэй биелүүлжээ.

Үүрэг гүйцэтгэх хугацаанд "Ковид-19" цар тахлын аюулын амаргүй үе таарсан ч бааз дотор үүрэг гүйцэтгэж буй нийт бие бүрэлдэхүүн болон орон нутгийн иргэдийн аюулгүй байдлыг 7 сарын хугацаанд ханган ажилласан бөгөөд үүнийг нь үнэлж ажиллагааны газар орны бүсийн командлагч өөрийн медалиноор шагнасан байдаг юм.

2002-2007 онд ҮБХИС-ийн Цэргийн нэгдсэн дээд сургуулийг Ерөнхий цэргийн командын офицер, төрийн захиргааны удирдлага мэргэжлээр суралцаж төгссөн, Зэвсэгт хүчний аварга шалгаруулах "Марш-тактик, тусгай бэлтгэл"-ийн үе үеийн аваргаар тодорч, хөнгөн атлетийн 400, 800, 1500, 3000 метрийн гүйлт, хөл бөмбөг, гардан тулааны тэмцээнүүдээс тэргүүн байруудыг нь түүж, цэрэгжлийн спортын дархлагдсан шилдэг тамирчин, төрийн торгон цэрэг билээ.

## ХҮН ХҮНТЭЙГЭЭ ХАРИЛЦАХ ХАРИЛЦААГ ЭРХЭМЛЭЖ ЯВААРАЙ ХЭМЭЭН УРИАЛЛАА



Соён гэгээрүүлэх ажлыг Монгол Улсын Батлан хамгаалахын сайдын дэргэдэх "Иргэний зөвлөл"-өөс 12 дугаар сарын 20-ны өдөр Хувьсгалт тэмцлийн ахмад зүтгэлтэн хурандаа О.Сэрдарийн нэрэмжит Цэргийн гавьяаны Улаан тугийн одонт Зэвсэгт хүчний 015 дугаар ангийн офицер, ахлагч болон хугацаат цэргийн алба хаагчдад "Сэтгэл зүй", "Харилцаа хандлага", "Эрүүл байхын үндэс "Эх орон" гэж юу вэ сэдвүүдээр харилцан яриа, ёс суртахууны төлөвшил олгох сургалтыг зохион байгуулж явууллаа.

Сургалтын эхэнд Монгол Улсын гавьяат багш, доктор, профессор, "Отгонтэнгэр" их сургуулийн багш, чөлөөнд байгаа хурандаа Б.Галиндэв "Эх оронч үзэл, бахархал", Монгол Улсын Төрийн соёрхолт, хүний гавьяат эмч, анагаах ухааны доктор профессор, Цэргийн төв эмнэлгийн зөвлөх эмч, чөлөөнд байгаа хурандаа Л.Жамбалжав "Цэргийн алба хаагчдын эрүүл мэндийн боловсрол" тэр дундаа нийгмийн халдварт өвчин болох сүрьеэ, БЗХӨ, элэгний вирусийн халдвар зэрэг сэдвээр лекц уншиж, сонирхолтой ярилцлага өрнүүлжээ.

Мөн Батлан хамгаалахын Ерөнхий хянан шалгагчийн ажлын албаны мэргэжилтэн, "Иргэний зөвлөл"-ийн нарийн бичгийн дарга хошууч А.Октябрь Батлан хамгаалах яамнаас хэрэгжүүлж буй бодлого, үйл ажиллагааны талаар бие бүрэлдэхүүнд мэдээлэл хүргэсний зэрэгцээ эл зөвлөлийнхөө зорилго, зорилтыг танилцуулан "Зөв харилцаа-Зөв хандлага"-ын талаар өгүүлж, алба хаагчдыг харилцаа, хандлага дээшлүүлж ажиллахыг уриаллаа.

Сургалтын төгсгөлд захирагчийн нэгдүгээр орлогч, штабын дарга дэд хурандаа Б.Болдбаяр "Мөрдөстэй бүхний бахархал болсон эрдэмтэн профессор эрхэм бэлтгэл хурандаа багш нарынхаа лекцийг дахин сонсож байгаадаа талархсанаа илэрхийлэн ангийнхаа түүхт 100 жилийн ойд зориулан эмхэтгэсэн номыг хадгалуулав.

Дэслэгч Б.ЗОЛЗАЯА

### ЦАГ АГААР

УЛААНБААТАР

ӨДӨР	ШӨНӨ
-19	-28

ӨМНӨД СУДАН

ӨДӨР	ШӨНӨ
38	24

### ВАЛЮТЫН ХАНШ

ВАЛЮТ	АВАХ	ЗАРАХ
USD	3.457	3.460
EUR	3.683	3.695
CNY	492	494
RUB	48.00	50,80
JPY	25.80	26,00
KRW	2.67	2.69

### ЗУРХАЙ



2022.12.21 / ЛХАГВА ГАРАГ / БИЛГИЙН ТООЛЛЫН 28

**ӨВЛИЙН ТЭРГҮҮН ЦАГААГЧИН ГАХАЙ САР НАЙМАН ЦАГААН МЭНГЭТЭЙ ШАР БИЧ ӨДӨР**

**Үс засуулбал:**

**Хэрүүл тэмцэл ирнэ**  
**НАРАН УРГАХ, ШИНГЭХ:**  
**08.39-17.01**

**Барилдлага:**

**Идэр**  
**ШҮТЭН БАРИЛДЛАГА:**  
**АВАХУЙ**

Тухайн өдөр гахай, хулгана, үхэр, луу, нохой жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба могой, морь жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Эл өдөр баяр баясгалангийн хурим үйлдэх, шинэ гэр барих, хувцас өмсөх, чимэг зүүх, бүжиг наадам үүсгэхэд сайн, эм найруулах, гэргий авах, үс авах, элч зарах, эд авахад сайн. Зүүн нүд татвал хэрүүл, тэмцэл болох, баруун нь бол эд хувцас олох, зүүн чих нь цангинавал зочин ирэх, баруун нь бол гаслан болох, нохой уливал галзуурах, хэрээ гуаглавал ураг садан эндэх, тагнай загатнавал хэн нэгний үхсэнийг сонсох, бие татвал гэнэт зочин ирэх, хөл татвал үхэл болохыг үзэх болой.

### КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

**Тохиолдол**  
Нийт: 658,881,463

**Эдгэрсэн**  
Нийт: 632,391,608

**Нас барсан**  
Нийт: 6,675,669

Цахим шууданд

# ЦЭРЭГ-СПОРТЫН ОЛОН ТӨРӨЛТИЙН ТЭМЦЭЭНД ЗЕНИТ АРТИЛЛЕРИЙН БАГ ТЭРГҮҮЛЭВ



Зэвсэгт хүчний 327 дугаар анги Дорнод аймгийн Биеийн тамир, спортын газартай хамтран хугацаат цэргийн алба хаагчдын дунд "Цэрэг спортын олон төрөлтийн цогцолбор тэмцээн"-ийг зохион байгуулж явууллаа. Тэмцээнийг гар барилдаан, гар дээр сунах, олс татах, буудлага, буухиа гэсэн 5 төрлөөр зохион байгуулж, нийлбэр дүнгээр байр эзлүүлэв.

Нэг багт 16 гишүүнтэйгээр нийт 7 баг хурд хүч, авхаалж самбаагаараа өрсөлдсөнөөс тэргүүн байрт Зенит артиллерийн батарей, дэд байрыг Гаубицийн батарей, гутгаар байрт 3 мотобуудлагын ротын баг тамирчид тус тус эзлэлээ.

Тэмцээнд оролцсон амжилттай байсан аймгийн тамирчин дайчдад амгийн тамир, спортын газрын дарга Б.Чимэддорж хандаж хэлсэн үгэндээ "Энэ удаагийн уралдаан өрсөлдөөн дүүрэн сайхан болж өнгөрлөө. Цэргийн хүмүүс учир гүйцэтгэл өндөр бөгөөд хурдан шаламгай юм. Эгнээнээсээ тив, дэлхийн олон тамирчин төрүүлдэг Зэвсэгт хүчний 327 дугаар ангитайгаа хамтран ажиллах нь нэр төрийн хэрэг билээ. Цаашид илүү өргөн хүрээнд алба хаагчдын бие бялдрын бэлтгэлжилтийг дээшлүүлэх чиглэлд хамтарна ажиллана гэдэгт итгэлтэй байна" гэлээ.

**Ахмад Э.МӨНХБАЯСАХ**



## "ЦЭРЭГТ МОРДСОН ХҮҮГЭЭРЭЭ ААВ НЬ БАХАРХАЖ БАЙНА" ГЭСЭН НЬ ХАМГИЙН ГОЁ



"Байлдагч байлдагчийнхаа ертөнцөөр" булангийнхаа анхны зочноор Зэвсэгт хүчний 327 дугаар ангийн хугацаат цэргийн алба хаагч, байлдагч Энхбатын Ганбат, Ганбаатарын Ганболд нарыг уриллаа.

Энэ нь сурвалжлагч бидний асуултаас илүү байлдагч нар албаныхаа тухай нэгнээсээ юу асууж, юу тодруулахыг хүсэж байгааг нь хуваалцах зорилготой бөгөөд ярилцлагын эхэнд зочдоо товчхон танилцуулъя.

Байлдагч Э.Ганбат нь Дорнод аймгийн Цагаан-Овоо сумынх, 21 настай. Эхээс тавуулаа, айлын отгон хүү. Цэргийн албанд татагдахаас өмнө "Сити" дээд сургуульд жүжигчний мэргэжлээр суралцаж байсан гуравдугаар дамжааны оюутан. Суралцаж буй мэргэжлээрээ олон кино, контент, дууны клипэнд тоглохоос эхлээд арын албанд нь ажиллаж байсан туршлагатай. "Хуйвалдаан", "Амьд бус амьдрал" уран сайхны кинонд туслах дүр бүтээж, "Surprise" контентын арын албанд нь байж.

Харин байлдагч Г.Ганболд Хэнтий аймгийн Биндэр сумынх, 20 настай. Эхээс долуулаа мөн л айлын отгон хөвгүүн. Тэдэнд ижил төсөөтэй олон чанар байсан бөгөөд хоёул буриад, айлын отгон, гар бөмбөгөөр хичээллэдэг спортлог залуус санж. Г.Ганболд ШУТИС-д цахилгааны инженер мэргэжлээр суралцаж байсан, хоёрдугаар дамжааны оюутан. Түүнийг илэрхийлэх гол чанар нь сумын алдарт уяач. Бүр гурван настайгаасаа 16 нас хүртлээ морь унаж, уясан гэнэ. "Гурван нас гэдэг дэгсдүүлсэн тоо юм биш үү" гэхэд "Үнэхээр бидний үед хүүхдүүд тэгж л морь унадаг байсан, үнэн шүү эгч ээ" гэв.

Байлдагч Э.Ганбат: -Цэрэгт

ирээд ямар байна. Аймгаас машинаар ачаад ангийн хашааны гадаа ирэхэд ямар мэдрэмж төрж байв?

Байлдагч Г.Ганболд: -Өөрөө хүсэн тэмүүлж ирсэн гэж худлаа хэлэхгүй. Цэргийн зарлан ирэхээр нь очоод бүртгүүлэл тэнцчихсэн. Тэгээд нэгэнт явахаас өөр зам байгаагүй учраас дуртай, дургүй царайлсаар машиндаа суусан. Мэдээж цэргийн орчны анхны төсөөлөл нь хатуу ширүүн гэсэн бодол байв. Харин ирсний дараа, тэр дундаа албандаа дассаны дараа анхны бодлоос минь тэс өөр газар байсан. Нээлттэй, эелдэг, сурч боловсрох, өөрийгөө хөгжүүлэх боломж дүүрэн. Миний хамгийн олзуурхаж байгаа чанар гэвэл цэргийнхний харилцаа, хандлага. Хүндлэл, нөхөрлөл дээр тогтсон алба юм байна гэдгийг тэдний харилцаагаар нь мэдэрч байгаадаа маш их баяртай байгаа.

Байлдагч Э.Ганбат: -Үнэхээр тийм шүү. Цэрэгт ирэхээс өмнөх үетэй харьцуулахад хувийн зохион байгуулалт маань сайжирч, хүнтэй харилцах соёлоос суралцаж байна. Ингэхэд та сумын алдарт уяач

гэсэн. Энэ талаар яриач?

Байлдагч Г.Ганболд: -Гурван настайгаасаа хурдан морь унаж, сум, аймаг, бүсийн наадамд олон түрүү, айраг авсан. 12 дугаар анги төгсөх хүртлээ хурдан мориор "амьсгалсан" нөхөр л дөө. Энэ бол аавын минь нөлөөлөл, хүмүүжил. Хэнтийчүүд аавыг минь андахгүй. Аймгийн алдарт уяач А.Ганбаатар гээд. Миний хувьд 2020 онд буюу 12 дугаар ангиа төгсдөг жил сумын удирдлагууд "Сумын алдарт уяач" цолыг олгосон.

Байлдагч Э.Ганбат: Хамгийн урамтай түрүү хэзээнийх байв?

Байлдагч Г.Ганболд -2019 онд манай суманд болсон бүсийн наадам. Миний их насанд уясан хул морь километрийн зайтай тасархай түрүүлж, эзнээ маш их баярлуулсан даа. Ингэхэд та аав, ээжийгээ хэзээ хамгийн сүүлд баярлуулсан бол?

Байлдагч Э.Ганбат: -Саяхан болж өнгөрсөн цэргийн тангаргийн баяраар. Аав, ээж минь хоёулаа ирсэн. Хэдий аав минь гагнуур хийж байгаад нэг нүднийхээ харааны чадварыг алдсан ч "Хүүгийнхээ цог жавхлантай алхаж явааг маш тод харлаа. Цэрэгт ирээд миний хүү их сайхан байна" гээд баярлахыг нь хараад уйлчихсан. Магад аав минь сайн харж чадаагүй ч сэтгэлдээ тийм л омогшил, бахархал тээж байгааг нь сонсоод маш их баярласан. Цаашдаа аав, ээжийг илүү их баярлуулах олон сайхан үйл явдал байгаа гэдэгт итгэдэг. Ялангуяа сургуулиа амжилттай төгсөж, чадалтай сайн жүжигчин болж баярлуулах нь миний туйлын хүсэл зорилго гэсээр тэд ярилцлагаа өндөрлүүлэв.

Байлдагч Г.Ганболд ангийнхаа батарейн захирагч, ахмад Б.Билгүүн, салааны захирагч, дэслэгч М.Бадамтамир нараас их зүйл суралцаж буйгаа өгүүлсэн бол байлдагч Э.Ганбат салааны захирагч Б.Бат-Эрдэнэ, артиллерийн дивизоны соёл хүмүүжлийн офицер, ахмад Э.Мөнхбаясах нарыг онцлон дурдаж байлаа. Тэдний цэргийн албаараа бахархах нь ярилцлагын ихэнх хувийг эзэлж байсан бөгөөд тэр бүгд нь чин сэтгэлийнх байв.

**Ахмад Д.БОЛОР**



## ҮЛЭЭВЭР ХӨГЖИМЧДИЙГ БЭЛТГЭХ СУРГАЛТ ҮРГЭЛЖИЛСЭЭР



ЗХЖШ-ын Цэргийн Зэвсэгт хүчний нэгтгэл, хөгжмийн албаны бүрэлдэхүүн ангиудын үлээвэр найрал Сүхбаатар аймаг дахь Зэвсэгт хөгжмийн гүйцэтгэх үүрэг, хүчний 338 дугаар ангийн 3ХЖШ-ын ҮЖҮНХ-ийн ололт үлээвэр найрал хөгжмийг амжилт, үр дүн, Олон улсын бэхжүүлэх зорилгын хүрээнд Цэргийн хөгжмийн наадамд үлээвэр хөгжимчдийг бэлтгэх оролцсон талаарх сонирхолтой сургалтыг 12 дугаар сарын 15-ны өдрөөс эхлүүлээд байна. зураг, бичлэгүүдийг үзүүлэн сурталчилж, хөгжмийн анхан шатны сургалтыг мэргэжлийн өндөр түвшинд заан сургаж байна.

Энэхүү сургалтын үеэр суралцагсад ЗХЖШ-ын Цэргийн хөгжмийн албаны танилцуулга, зорилго, зорилт, Дэслэгч Б.АМГАЛАНБОЛД

Сургалт

## МОНГОЛ БИЧГИЙН ХИЧЭЭЛ №41

ЯА ҮСГИЙН БҮТЭЦ, ЗӨВ, ЦЭВЭР БИЧИХ ЯА бол дэвсгэр бус үсэг. Эртний монгол хэлнээ дэвсгэр үсэг байсан. Бүтэц, зурлагын хувьд өмнөх хичээлээр үзсэн ЖА үсгийн адил шилбэт үсэг бөгөөд шилбийн үзүүрийг дээш эргүүлсхийн этгэр болгож бичдэгээр ЖА-гаас ялгаатай. Монгол бичгийн ЯА гийгүүлэгчийг кириллээр Й-ээр тэмдэглэдэг.

Уншигч та бүхэн үгийн эхэнд, дунд, төгсгөлд ордог ЙА, ЙЭ, ЙИ, ЙО, ЙУ, ЙӨ, ЙҮ гэж аялгуулан дуудаж үе үсэг хэрхэн хувирч буйг нүдлэн тогтоогтун. Бичмэл тигээр:

